



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн ИТХ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БНА-2022/150/НА-СТА-ТШЗ

Баянхонгор 2022 он	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576      Цахим хаяг: munkhatb@audit.gov.mn Аудитын менежер: А.Цээням Утас: 99442140      Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn Аудитор: П.Амаржаргал Утас: 88106992      Цахим хаяг: amarjargalp@audit.gov.mn Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a>
-----------------------	---

**Агуулга**

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	төгрөгөөр .. 4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	төгрөгөөр .. 5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	төгрөгөөр.. 6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	төгрөгөөр.... 7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	төгрөгөөр .. 8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	9
3. Аудитын тайлан .....	9
3.1 Ерөнхий зүйл .....	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	10
3.4 Материаллаг байдал .....	10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	12
3.8 Аудитын гол асуудал.....	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	13
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	14
4. Аудитын илрүүлэлт .....	14
4.1 Зөвлөмж.....	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	15

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,  
Баянхонгор сум, Номгон баг  
Утас, факс 7044 2584  
E-mail; bayankhongor@audit.gov.mn

᠒᠐᠒᠒.᠐᠒.18 № ᠒/48

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Г АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ Г

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

D:\alban bichig\A4.docx

005020318

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

A handwritten signature in black ink is written over a red rectangular official stamp. The stamp contains Mongolian text and a central emblem. The signature is a stylized, cursive script.

Б.МӨНХБАТ

**2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл**

**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>15,862,200.00</u></b>	<b><u>13,222,312.00</u></b>
33	АВЛАГА	00.00	389,112.00
335	Бусад авлага	00.00	389,112.00
3351	Байгууллагаас авах авлага	00.00	389,112.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>15,862,200.00</b>	<b>12,833,200.00</b>
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>15,862,200.00</b>	<b>12,833,200.00</b>
35410	Бичиг хэргийн материал	833,110.00	1,754,110.00
35420	Аж ахуйн материал	10,529,090.00	11,079,090.00
35440	Түлш, шатах тослох материал	4,500,000.00	00.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>68,195,624.91</u></b>	<b><u>97,943,132.13</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>68,195,624.91</b>	<b>97,943,132.13</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>68,195,624.91</b>	<b>97,943,132.13</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,268,000.00	2,268,000.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-1,438,131.99	-1,475,931.99
39203	Авто-тээврийн хэрэгсэл	157,549,000.00	157,549,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-117,607,333.39	-125,867,333.47
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	44,019,460.00	76,075,680.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-32,601,061.04	-31,235,759.01
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	39,481,830.00	43,509,550.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-23,789,438.67	-23,193,373.40
39217	Ном	313,300.00	313,300.00
39301	Программ хангамж	450,000.00	450,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-450,000.00	-450,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>84,057,824.91</u></b>	<b><u>111,165,444.13</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>00.00</b>	<b>00.01</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>84,057,824.91</u></b>	<b><u>111,165,444.13</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>84,057,824.91</b>	<b>111,165,444.13</b>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	206,028,121.00	206,028,121.00
51101	Өмч: - төрийн	206,028,121.00	206,028,121.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>-123,273,962.09</b>	<b>-96,166,342.88</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	-123,273,962.09	-123,273,962.09
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	27,107,619.22
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,303,666.00	1,303,666.00
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>84,057,824.91</u></b>	<b><u>111,165,444.13</u></b>

Баянхонгор аймгийн ИТХ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн  
санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>794,025,500.00</b>	<b>948,994,800.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>30,000,000.00</b>	<b>11,623,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	30,000,000.00	11,623,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	30,000,000.00	11,623,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	30,000,000.00	8,917,000.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	00.00	2,706,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>764,025,500.00</b>	<b>937,371,800.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	440,000,000.00	138,060,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	440,000,000.00	138,060,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	324,025,500.00	799,311,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	324,025,500.00	799,311,800.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>630,568,671.67</b>	<b>922,395,601.06</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>630,568,671.67</b>	<b>922,395,601.06</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	189,093,171.67	780,102,510.82
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	38,620,606.00	216,948,423.34
210101	Үндсэн цалин	38,620,606.00	216,948,423.34
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	4,827,571.00	28,271,165.43
210201	Тэтгэврийн даатгал	3,282,751.00	19,829,656.99
210202	Тэтгэмжийн даатгал	386,205.00	2,175,088.91
210203	ҮОМШӨ-ний даатгал	308,964.00	919,906.58
210204	Ажилгүйдлийн даатгал	77,240.00	1,231,652.77
210205	Эрүүл мэндийн даатгал	772,411.00	4,114,860.18
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	11,151,360.00	41,558,709.00
210401	Бичиг хэрэг	1,351,600.00	7,461,991.00
210402	Тээвэр, шатахуун	9,000,000.00	30,247,616.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	779,760.00	2,976,102.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	00.00	873,000.00
210408	Бараа материал акталсны зардал	20,000.00	00.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	00.00	8,350,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	30,000.00
210604	Урсгал засвар	00.00	8,320,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	20,511,000.00	7,927,400.00
210701	Гадаад албан томилолт	18,300,000.00	00.00
210702	Дотоод албан томилолт	2,211,000.00	7,927,400.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	81,960,000.00	270,440,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	80,750,000.00	269,030,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	200,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,060,000.00	1,060,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	150,000.00	150,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	32,022,634.67	206,606,813.05



**Баянхонгор аймгийн ИТХ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	28,431,600.00	187,205,300.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	3,591,034.67	19,401,513.05
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>441,475,500.00</b>	<b>142,293,090.24</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>441,475,500.00</b>	<b>141,378,600.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	440,189,000.00	123,970,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,286,500.00	17,408,600.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>00.00</b>	<b>914,490.24</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	914,490.24
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>163,456,828.33</b>	<b>26,599,198.95</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>660,546.01</b>	<b>5,866,579.78</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	660,546.01	5,866,579.78
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>-660,546.01</b>	<b>-5,866,579.78</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>162,796,282.32</b>	<b>20,732,619.17</b>

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>1,200,843,400.00</b>	<b>937,371,800.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,200,843,400.00</b>	<b>937,371,800.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>567,500,000.00</b>	<b>138,060,000.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	567,500,000.00	138,060,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>633,343,400.00</b>	<b>799,311,800.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	633,343,400.00	799,311,800.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>1,192,402,900.00</b>	<b>897,648,200.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,192,402,900.00</b>	<b>897,648,200.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>579,377,522.79</b>	<b>755,355,109.76</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>158,993,915.55</b>	<b>217,841,506.99</b>
210101	Үндсэн цалин	96,307,073.55	149,744,800.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,714,000.00	9,483,000.00
210104	Урамшуулал	55,972,842.00	58,613,706.99
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>20,201,117.64</b>	<b>27,767,193.77</b>
210201	Тэтгэврийн даатгал	13,819,212.07	19,400,649.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,606,849.14	2,175,089.26
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,285,477.74	1,731,791.47
210204	Ажилгүйдлийн даатгал	317,232.31	404,671.24
210205	Эрүүл мэндийн даатгал	3,172,346.38	4,054,992.80
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>34,797,489.60</b>	<b>35,273,709.00</b>
210401	Бичиг хэрэг	3,597,490.00	7,297,607.00
210402	Тээвэр, шатахуун	28,000,000.00	25,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,199,999.60	2,976,102.00



**Баянхонгор аймгийн ИТХ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	20,000,000.00	8,900,000.00
210604	Урсгал засвар	20,000,000.00	8,900,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	21,737,000.00	7,927,400.00
210701	Гадаад албан томилолт	18,300,000.00	00.00
210702	Дотоод албан томилолт	3,437,000.00	7,927,400.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	125,060,000.00	270,440,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	123,600,000.00	269,030,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000.00	200,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,060,000.00	1,060,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	150,000.00	150,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	198,588,000.00	187,205,300.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	198,588,000.00	187,205,300.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>613,025,377.21</b>	<b>142,293,090.24</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	603,911,600.00	141,378,600.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	564,887,000.00	123,970,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	39,024,600.00	17,408,600.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	9,113,777.21	914,490.24
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	9,113,777.21	914,490.24
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>8,440,500.00</b>	<b>39,723,600.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>8,440,500.00</b>	<b>39,723,600.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>8,440,500.00</b>	<b>39,723,600.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	8,440,500.00	39,723,600.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	8,440,500.00	39,723,600.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>-8,440,500.00</b>	<b>-39,723,600.00</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	00.00	00.00
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	00.00	00.00

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	206,028,121.00	2,403,666.00	-176,488,279.74	31,943,507.26
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	<b>206,028,121.00</b>	<b>2,403,666.00</b>	<b>-176,488,279.74</b>	<b>31,943,507.26</b>
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	10,353,397.65	10,353,397.64
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	206,028,121.00	1,303,666.00	-123,273,962.09	84,057,824.91
D01	2021 оны 01-р сарын 31-нээрх үлдэгдэл	206,028,121.00	1,303,666.00	-123,273,962.09	84,057,824.91
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	<b>206,028,121.00</b>	<b>1,303,666.00</b>	<b>-123,273,962.09</b>	<b>84,057,824.91</b>
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	27,107,619.22	27,107,619.21
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	206,028,121.00	1,303,666.00	-96,166,342.88	111,165,444.12



Баянхонгор аймгийн ИТХ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>799,311,800.00</b>	<b>798,397,309.76</b>	<b>914,490.24</b>	<b>99.89</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	799,311,800.00	798,397,309.76	914,490.24	99.89
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	778,841,800.00	778,018,709.76	823,090.24	99.89
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	217,897,300.00	217,841,506.99	55,793.01	99.97
210101	Үндсэн цалин	149,744,800.00	149,744,800.00	0.00	100.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,483,000.00	9,483,000.00	0.00	100.00
210104	Урамшуулал	58,669,500.00	58,613,706.99	55,793.01	99.90
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,233,100.00	27,767,193.77	465,906.23	98.35
210201	Тэтгэврийн даатгал	19,479,600.00	19,400,649.00	78,951.00	99.59
210202	Тэтгэмжийн даатгал	2,184,400.00	2,175,089.26	9,310.74	99.57
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,818,400.00	1,731,791.47	86,608.53	95.24
210204	Ажилгүйдлийн даатгал	644,900.00	404,671.24	240,228.76	62.75
210205	Эрүүл мэндийн даатгал	4,105,800.00	4,054,992.80	50,807.20	98.76
2104	Хангамж, бараа материалын зардал	35,274,000.00	35,273,709.00	291.00	100.00
210401	Бичиг хэрэг	7,297,800.00	7,297,607.00	193.00	100.00
210402	Тээвэр, шатахуун	25,000,000.00	25,000,000.00	0.00	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,976,200.00	2,976,102.00	98.00	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	31,500,000.00	31,500,000.00	0.00	100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	19,600,000.00	19,600,000.00	0.00	100.00
210602	Тавилга	3,000,000.00	3,000,000.00	0.00	100.00
210604	Урсгал засвар	8,900,000.00	8,900,000.00	0.00	100.00
2107	Томилолт, зочны зардал	7,927,400.00	7,927,400.00	0.00	100.00
210702	Дотоод албан томилолт	7,927,400.00	7,927,400.00	0.00	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	253,680,000.00	253,380,000.00	300,000.00	99.88
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	251,970,000.00	251,970,000.00	0.00	100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500,000.00	200,000.00	300,000.00	40.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,060,000.00	1,060,000.00	0.00	100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	150,000.00	150,000.00	0.00	100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	204,330,000.00	204,328,900.00	1,100.00	100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	204,330,000.00	204,328,900.00	1,100.00	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	20,470,000.00	20,470,000.00	0.00	100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	20,470,000.00	20,470,000.00	0.00	100.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	2,970,000.00	2,970,000.00	0.00	100.00



**Баянхонгор аймгийн ИТХ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	17,500,000.00	17,408,600.00	91,400.00	99.48
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>799,311,800.00</b>	<b>798,397,309.76</b>	<b>914,490.24</b>	<b>99.89</b>
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>799,311,800.00</b>	<b>798,397,309.76</b>	<b>914,490.24</b>	<b>99.89</b>
132001	Орон нутгийн төсвөөс	799,311,800.00	798,397,309.76	914,490.24	99.89
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>15.00</b>	<b>15.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
620001	Удирдах ажилтан	06.00	06.00	0.00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	02.00	02.00	0.00	100.00
620003	Үйлчлэх ажилтан	07.00	07.00	0.00	100.00

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>567,500,000.00</b>	<b>138,060,000.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>567,500,000.00</b>	<b>138,060,000.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>567,500,000.00</b>	<b>138,060,000.00</b>
<b>2108</b>	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	567,500,000.00	138,060,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	567,500,000.00	138,060,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>567,500,000.00</b>	<b>138,060,000.00</b>
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>567,500,000.00</b>	<b>138,060,000.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>567,500,000.00</b>	<b>138,060,000.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	567,500,000.00	138,060,000.00

**3. Аудитын тайлан**

**3.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор П.Амаржаргал гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, аудитын менежер А.Цээням, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн ИТХ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 84 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

Санхүүгийн тайлант хугацаанд аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга Т.Норов нэгдүгээр гарын үсгийг, нягтлан бодогч Ариунбаяр хоёрдугаар гарын үсгийг тус тус зурж хөрөнгө мөнгийг захиран зарцуулсан байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Аймгийн ИТХ-ын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

"Нутгийн өөрийн удирдлагын алсын хараатай бодлого, ил тод, хариуцлагатай төрийн үйлчилгээ, иргэдийн бүтээлч санаачилга, өргөн боломжид суурилсан, тогтвортой хөгжлийг бий болгож, иргэдийнхээ амьдралын чанарыг дээшлүүлэн аж жаргалтай, амар тайван амгалан амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд оршино" гэсэн эрхэм зорилгын доор үйл ажиллагаагаа явуулж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Баянхонгор аймгийн ИТХ-ын захирлын 2021 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн А/37 тоот тушаалаар батлагдсан салбарын хэмжээнд мөрдөж байгууллагын өөрийн онцлогт нийцүүлэн боловсруулж холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримтыг ашиглаж байна.

Тус байгууллага нь дотоод аудитын албан байхгүй бөгөөд дотоод аудитын чиг үүргийг аймгийн Санхүүгийн хяналт аудитын алба нь хэрэгжүүлдэг ба Баянхонгор аймгийн ИТХ-ын 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн ИТХ-ын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд төлөвлөлтийн үе шатны материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл "Дунд" гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 630,568.6 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 6,305.6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 6,456.7 мянган төгрөгөөр тогтоосон.



Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин гүйцэтгэлийн үе шатанд хянаж үзэхэд 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлаас тооцоход гүйцэтгэлийн материаллаг байдал 6,456.7 мянган төгрөг байгаа тул шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Баянхонгор аймгийн ИТХ-ын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө 111,165.4 мянган төгрөг болж өмнөх оноос 27,107.6 мянган төгрөгөөр буюу 24.3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
A	1	2	3=2-1
<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	15,862.20	13,222.30	-2,639.90
Мөнгөн хөрөнгө	-	-	
Авлага	0.00	389.1	389.10
Урьдчилгаа	-	-	
Бараа материал	15,862.20	12,833.20	-3,029.00
<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	68,195.60	97,943.10	29,747.50
Үндсэн хөрөнгө	244,081.50	280,165.50	36,084.00
Хуримтлагдсан элэгдэл	-175,885.90	-182,222.30	-6,336.40
<b>Нийт хөрөнгө</b>	<b>84,057.80</b>	<b>111,165.40</b>	<b>27,107.60</b>
Өр төлбөр	0	0	0.00
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	84,057.80	111,165.40	27,107.60
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>84,057.80</b>	<b>111,165.40</b>	<b>27,107.60</b>

Бараа материалын дансны үлдэгдэл 12,833.2 мянган төгрөг болж 3,029.0 мянган төгрөгөөр буурсан нь шатах тослох материалын үлдэгдэл өмнөх оноос 4,500.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн ба ангилагдаагүй зардлаас 1,083.0 мянган төгрөгийн хурлын ерөөний засварын материал, аймгийн онцгой комиссоос 873.0 мянган төгрөгийн халдвар хамгааллын хэрэгсэл хүлээн авч орлогоор бүртгэсэн нь бараа материал голлох нөлөөг үзүүлж байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 280,165.5 мянган төгрөг болж 36,084.0 мянган төгрөгөөр өссөн нь аймгийн ЗДТГ-аас шилжиж ирсэн 6,375.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлаас 3,908.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 5,009.0 мянган төгрөгийн тавилга хэрэгсэл, төсвийн хөрөнгөөр 34,899.8 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 4,823.8 мянган төгрөгийн тавилга хэрэгсэл авч Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн 271-р тогтоолын 4.1.1-д заасны дагуу тус тус холбогдох дансанд орлогоор бүртгэж 18,931.6 мянган төгрөгийн хөрөнгийг акталж данс бүртгэлээс хассантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 111,165.4 мянган төгрөг болж 27,107.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 27,107.6 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт



Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх зарлагыг 666,331.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 979.9 мянган төгрөгөөр өсгөж 667,311.8 мянган төгрөгөөр анх батлагдсан ба 2021 оны 12 дугаар сард төсөвт зохицуулалт хийгдэж 799,311.8 мянган төгрөг болж 132,000.0 мянган төгрөг буюу 16.5 хувиар өсөж батлагдсан байна.

### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 799,311.8 мянган төгрөгийн төсөв баталснаас орон нутгийн төсвөөс 799,311.8 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 799,311.8 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 798,397.3 мянган төгрөгийг зарцуулж 914.4 мянган төгрөг буюу 0.1 хувийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 798,397.3 мянган төгрөг буюу 99.9 хувьтай байгаа нь цалин, хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал 55.3 мянга, ажил олгогчоос олгох нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 465.9 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр 300.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн Төрийн сан банкин дахь 100030050401 тоот дансанд ахмад дайчдын нөхөн олговорт 121,000.0 мянга, хамтарсан багийн сургалтын зардалд 17,060.0 мянга нийт 138,060.0 мянган төгрөгийг олгосон бөгөөд ахдам дайчдын нөхөн төлбөрт Д.Мядагмаа 81,000.0, Ш.Өлзийбат 40,000.0 мянга, хамтарсан багийн сургалтын зардалд 6,270.0 мянга, цайны зардалд 2,090.0 мянга, үйл ажиллагааны зардалд 8,700.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 6 дугаар хуралдааныг нүүдлийн байдлаар Шинэ суурьшлын бүсэд зохион байгуулсан.

Аймгийн нийгэм, эдийн засгийн бодлогын уялдаа холбоог хангах, орон нутгийн баялаг бүтээгчдийг дэмжих зорилгоор аймгийн ИТХ-аас “Үйлдвэрлэл үйлчилгээг хөгжүүлж, ажлын байрыг нэмэгдүүлэн, ажилгүйдэл ядуурлыг бууруулах арга зам” сэдэвт нээлттэй сонгог хэлэлцүүлэг 2 удаа зохион байгуулж, иргэд хувийн хэвшлийнхэн болон төрийн байгууллагын албан хаагчдыг оролцууллаа. Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс зохион байгуулж буй "Би биш бид" аяны хүрээнд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын



дэргэдэх "Мини парламент"-аас "Би биш бид хөгжинө" сэдэвт мэтгэлцээний тэмцээнийг зохион байгуулсан байна.

Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Өсөхбаяр санхүүгийн тайлангийн аудит хийсэн бөгөөд тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх оны санхүүгийн тайлангийн мэдээллийг хамруулаагүй болно.

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан 53 арга хэмжээг төлөвлөж хэрэгжилт 88%-тай гэж тайлагнасан байна.

### **3.8 Аудитын гол асуудал**

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал 922,395.6 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 291,827.0 мянган төгрөгөөр буюу 31.6 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд нь томилолтын зардал өмнөх оноос буурсан бол бусад зардлууд нь өмнөх оноос буурсан үзүүлэлттэй байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас шилэн дансны 2021-2022 оны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх ерөнхий чиглэл"-ийн 1 дүгээр хавсралтад заасан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тус байгууллага нь 2021 онд Шилэн дансны нэгдсэн системд нийт 799,311.8 мянган төгрөгийн 151 мэдээлэл байршуулахаас хугацаа болоогүй 2 мэдээлэл, мэдээлбэл зохих 149 мэдээллээс 95,506.9 мянган төгрөгийн мэдээлэл зэрэг 36 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

#### **3.9.2 Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын хэрэгжилт**

Урсгал төсвийн зарцуулалт нь гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 799,311.8 мянган төгрөгийн санхүүжилт авч урсгал үйл ажиллагаанд 798,397.3 мянган төгрөгийг зарцуулж 914.4 мянган төгрөг буюу 0.1 хувийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 9,832.8 мянган төгрөгийн конторын тавилга хэрэгсэл бэлтгэсэн нь Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга

хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын “1.4. энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх” гэсэн заалттай бүрэн нийцэхгүй байна.

### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй байна.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 3 заалт бүхий зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлж ажиллаж хэрэгжилтийн тайланг 2021 оны 08 дугаар сарын 24-ны өдрийн 16/291 тоот албан бичгээр ирүүлсэн ба зөвлөмжийн хэрэгжилтийг шалгах аяны хүрээнд шалгасан байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байхгүй

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар 134,096.8 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс санхүүгийн аудитын 24,869.1 мянга, нийцлийн аудитын 105,339.7 мянган төгрөгийн алдаа зөрчлийг дахин давтан гаргахгүй байх 3 заалт бүхий зөвлөмж өгөв.

### 4.1 Зөвлөмж

4.1.1 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлаас ИТХ-ын даргын захирамжаар төлөвлөгөөнд тусгаагүй зардлыг санхүүжүүлсэн байна.

Энэ нь Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1. “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг энэ хуульд заасны дагуу баталсан хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу явуулна” гэсэн заалтыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн:** Цаашид хуулийн хэрэгжилтийг хангаж батлагдсан төлөвлөгөө хөтөлбөрийн дагуу зардлыг санхүүжүүлэн ажиллах зөвлөмж өгөх

4.1.2 Тайлант онд батлагдсан төсвийн хөрөнгөөр 12 дугаар сард 98,32.8 мянган төгрөгийн тавилга хэрэгсэл бэлтгэсэн байна.

Энэ нь Засгийн газрын 2021 оны 2021 оны 2 дугаар сарын 17-ны 43 дугаар тогтоолын “1.4. энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх” гэсэн заалтыг зөрчиж байна.

**Шийдвэрлэсэн:** Цаашид байгууллагын удирдлага Засгийн газар болон дээд шатны байгууллагаас гаргасан тушаал шийдвэрийг мөрдөн ажиллах.

4.1.3 Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаа болоогүй 2 мэдээлэл мэдээлбэл зохих 149 мэдээллээс цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ өссөн дүнгээр, Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт, Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт, аван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ,

**Баянхонгор аймгийн ИТХ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

нийлүүлэгчийн нэр, хаяг, хөрөнгө оруулалт, тендерийн ерөнхий зэрэг 95,506.9 мянган төгрөгийн мэдээлэл зэрэг 36 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.2, 6.3, 6.4, 6.5... 6.4.4.таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг; 6.4.5.цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр... гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн:** Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл 6.1, 6.2, 6.3, 6.4, 6.5 дахь заалтуудын хуулийн цаглаварт хугацаанд мэдээллийг бүрэн, хугацаанд нь үнэн зөв мэдээлж байх.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

№	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
А	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1	ТШЗ	1	24.9	0	0	0	0	0	0	1	24.9
	Дүн										
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
1	ТШЗ	2	105.3	0	0	0	0	0	0	2	105.3
	Дүн										
	<b>НИЙТ ДҮН</b>	<b>3</b>	<b>134.1</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>3</b>	<b>134.1</b>

\_\_\_\_\_оОо\_\_\_\_\_